

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.БААСАНСҮРЭНГИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

2024.12.04

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт /	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэл тийн хувь
1	2	3	4	5	6	7	
НЭГ. "ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЭМЭГТЭЙЧҮҮД, ЖЕНДЭРИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Эмэгтэйчүүдийг хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо 8	5	8	<p>Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөрийг аймгийн хэмжээнд 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна. 2024 онд орон нутгийн төсвөөс 50 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил манлайлал, оролцоог нэмэгдүүлэх зөвлөгөөн сургалт 11 төрлийн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, 4600 гаруй охид эмэгтэйчүүдийг хамруулж, хөтөлбөрийн хэрэгжилт 98 хувьтай байна. Үүнд</p> <ul style="list-style-type: none"> ➤ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг утган "Хайр нэмье" сэтгэлзүйн өдөрлөг, хууль хүчний 6 байгууллагын дунд "Мөрдестэй бүсгүйчүүд" арга арга хэмжээг зохион байгуулж 800 гаруй эмэгтэйчүүдийг хамруулсан. ➤ Гадаад дотоодын төсөл хөтөлбөрт эмэгтэй бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, холбон зуучлах, хөдөлмөрт зуучлах, гоо зүйн чиглэлээр "Монгол дахь гоёлын шивээс нүүр будалтын холбоо" НҮТББ-ын хамтран артист гоёлын шивээсний сургалтыг 3 сарын турш үе шаттай зохион байгуулж, давхардсан тоогоор 45 эмэгтэйг хамруулсан, амжилттай суралцсан 10 эмэгтэйг ажлын байраар ханган ажиллаж байна. ➤ Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Эрдэнэтийн ээжүүдийг 	2024.01.01 2024.12.30	100

						чадавхжуулах" төрийн бус байгууллагатай хамтран гар урлалын төрөл, хийцийг өргөжүүлэх судалгаа хийж, туршлага судлан, З төрлийн гар урлалын шинэ төрлийг нэвтрүүлэн урлангийнхаа ээжүүдэд 5 удаагийн сургалтыг 120 гаруй эмэгтэйчүүдийг хамруулсан. Мөн анхны бүтээлээ гарган салбар дэлгүүртээ худалдаанд гарган ажиллаж байна.		
2.	Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэд хүмүүжлийн зөрөг арга "токкацу" арга зүйг түгээн дэлгэрүүлэх, сургалт, нөлөөллийн ажлыг эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан байгуулах зохион	Эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн хамрагдалт 40 хувь байна.	20%	40%	> "ГОО ОХЬ ОЮУНЛАГ НОМ" НҮТББ-тай хамтран Гэртээ хүүхдээ хардаг болон өрх толгойлсон ээжүүд болон бага насын хүүхдүүдэд уншлага-иог хосолсон сургалтыг 7 хоног 2 удаа хэрэгжүүлж байна. Хагас жилийн байдлаар 50 хүүхэд эмэгтэйчүүд хамрагдсан. > Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах чиглэлээр Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "Хойд бусийн зөвлөгөөн" зохион байгуулан Хөвсгөл, Булган, Орхон аймгийн 200 гаруй бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хамрагдаж, туршлага судлаж, бизнес санаагаа дэлгэрүүлсэн.	Японы хүмүүнлэгийн ухааны "COYKA" их сургуулийн зөвлөх Профессор Ёшихоро Огава багштай хамтран Орхон аймагт "Токкацу" арга зүйг түгээн дэлгэрүүлэх ажлыг Засаг даргын Тамгын газар болон Боловсролын газартай хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 1900 гаруй эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч нарыг хамрууллаа. Нийт 150 багш Токкацу арга зүйн 2 модуль арга зүйн сургалтад хамрагдаж үнэмлэхээ гардаж авсан. 14 багш япон улсад туршлага сурлаж арга зүйгээ дээшлүүлж сургагч багшаар бэлтгэгдсэн үр дүнтэй байна. Үнд: Ерөнхий боловсролын бага ангийн нийт 110 багшид 5 удаагийн сургалт, зөвлөгөөн, 12 сургуулийн 18 багштай хамтарсан хичээл зааж, зөвлөгөө өгч ажилласан. Хүүхэд хүмүүжлийн эсрэг арга, хүүхэдтэйгээ ярилцах арга зүйн сургалтыг 12 сургуулийн 800 гаруй багш, эцэг эх, асран хамгаалагчдад хургэн ажилласан. 117	2024.01.01 2024.12.30	100

					байгууллагын эцэг эхийн зөвлөл 60% хамрагдсан. Үр дүнд бага боловсролын багш нарын 45 хувь хүүхэд хүмүүжлийн зерэг арга зүйн сургалтад хамрагдсан. Багш нараар дамжуулан эцэг эх асран хамгаалагч нарын хүүхэдтэйгээ харилцах арга зүйн мэдлэг мэдээлэл нэмэгдэнэ. Мөн хөтөлбөрийн хурээнд 10 дугаар сард 7 сургуулийн 10 багш Япон улсад туршлага судалсан. Тэдний хүүхэд хүмүүжлийн зерэг арга, Токкацу арга зүйн мэдлэг ойлголт дээшлүүлсэн. Японы сургууль, багш нараас суралцсан арга туршлагаа 2 багт хуваагдан бага ангийн багш нар болон багийн сургалтын менежерүүдэд сургалт хэлэлцүүлэг 5 удаа зохион байгуулан 150 гаруй багш нарыг хамруулсан.		
3.	Гэр бүлийн боловсрол олгох сургалт, нэлөөллийн ажлыг зохион байгуулах	нийт өрхийн 35 хувь	30%	35%	<p>2024 онд гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр нийт 19 төрлийн сургалт, нэлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 14515 өрхийг хамруулсан нь аймгийн нийт өрхийн 48.4%-ийг зээлж байна.</p> <p>Мөн гэр бүлийн 34 сургагч багш бэлтгэн гэрчилгээ олгож, тэдгээрээр дамжуулан аж ахуй нэгж байгууллага, хувийн хэвшлийн албан хаагчид, өсвөр үе, залуучуудад сургалт нэлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулсан нь бух давхаргын иргэн, өрх, өсвөр үе залуучуудын гэр бүлийн боловсролын талаарх мэдлэг ойлголт сайжран, харилцаа хандлага дээшилсэн байна. Дэлхийн гэр бүлийн өдөрлөгөөр "Харилцааны гайхамшиг" ТББ-тай хамтран 20 өдөр өглөөний уулзалтыг зохион байгуулж, уулзалтад төрийн болон төрийн өмчийн байгууллага, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ажилчдад гэр бүлийн хамт оролцох боломжийг олгосон нь тэдний гэр бүл дэх харилцаа хандлага өөрчлөгдсөн үр дүнтэй байна. Гэрлэхийн өмнө авв ээж байх, боловсрол олгох, сургалтыг ӨЭМТ-Үүдтэй хамтран "Нийгмийн эрүүл мэндэд бидний оролцоо" аяны хүрээнд шинээр төрөх ээжүүдийг гэр бүлийн хүний хамт сургалт нэлөөллийн ажилд хамруулан ажиллаж эцэг, эх байх үүрэг хариуцлага, хүүхдээ асрахуйн сургалтыг зохион байгуулахаар 4.6 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг Технологийн их сургууль, Политехникийн коллеж,</p>	2024.01.01 2024.12.30	100

					Маргад дээд сургуулийн нийт 1093 оюутан сургчдад хүргэж, тэдний гэр бүлийн боловсролын талаарх мэдлэг нэмэгдсэн.		
ХОЁР. "ИРГЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЧИГЛЭСЭН ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД, ЖЕНДЭРИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, ЛАВЛАГАА ЗӨВЛӨМЖ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	Хүүхдийн элч, Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, түр хамгаалах байрны үйл ажиллагааг тогтмолжуулах, мэргэжил арга зүйгээр хангах	Эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийн 80 хувийг хамруулсан байна.	75%	80%	<p>Аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын 28 хамтарсан баг, нийт 202 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор "Манлайлагч хамтарсан баг" шалгаруулах аяныг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран бүх хамтарсан багийн гишүүдийг хамруулан урлаг, спорт, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулж, тэдний идэвх, оролцоо нэмэгдсэн. Хамтарсан багийн гишүүдийг мэдээллээр хангах, уялдаа холбоог сайжруулах, шинэчлэн батлагдсан Хүүхэд хамгааллын хуулийг сурталчлах сургалтыг хуваарийн дагуу үе шаттай зохион байгуулж нийт 500 гаруй иргэдийг хамруулж, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн. Мөн 8 цэцэрлэг, сургууль, Политехникийн коллежтой хамтран хүүхэд хамгааллын сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж 1020 гаруй эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдийг хамруулсаннаар тэдний хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх мэдлэг, чадвар дээшилсэн. Хамтарсан багаар дамжуулан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг нийт 2430 иргэн авснаас 1339 хүүхэд хамрагдан нэн шаардлагатай хамгааллын үйлчилгээг авсан байна. "Зуслан" хөтөлбөр, "Номин" даатгалын үйлчилгээ, хүүхдийн ордны хөгжлийн хөтөлбөрийн ардын бүжиг, хар уран зураг, шатар, төгөлдөр хур, математик, гадаад хэл зэрэг дугуйлан сургалтад 497 хүүхэд хамруулсан нь эрсдэлт Эрсдэлийн программд байгаа хүүхдүүдийн 81 хувийг хамруулсан байна.</p>	2024.01.01 2024.12.30	100
2.	Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 95 хувь байна.	90%	95%	2024 онд улсын хэмжээнд хэрэгжүүлдэг эрсдэлийн программд бүртгэлтэй эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Хүүхдийн ордны урлаг, соёл, спортын 7 төрлийн хөтөлбөр, "Янзага"	2024.01.01 2024.12.30	100

	байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах /108 утас бусад өргөдөл гомдол/				зуслангийн зуны хөтөлбөр, "Номин" даатгал, эрүүл мэнд, хууль эрх зүйн холбон зуучлах үйлчилгээнд давхардсан тоогоор 1123 хүүхдийг хамрууллаа. Тайлант онд "Зуслан" хөтөлбөр, "Номин" даатгалын үйлчилгээ, хүүхдийн ордны хөгжлийн хөтөлбөрийн ардын бүжиг, хар уран зураг, шатар, төгөлдөр хур, математик, гадаад хэл зэрэг дугуйлан сургалтад 497 хүүхэд хамруулсан нь эрсдэлт Эрсдэлийн программд байгаа хүүхдүүдийн 81 хувийг хамруулсан байна. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 2024 оны 12 сарын байдлаар 254 дуудлага ирсэн байна. Хаасан - 243 дуудлага байна. Ажиллаж байгаа 11 дуудлага байна. Шийдвэрлэлт 95.6 хувь байна. 2023 оны мөн үетэй харьцуулахад дуудлагын тоо 0.7 хувиар нэмэгдэж, гэр бүлийн орчин дэхь дуудлагын тоо 4,8 хувиар буурч, боловсролын орчин дэхь дуудлагын тоо 40 хувиар нэмэгдсэн байна. Хүүхдийн тусламжийн 108 утасны чанар үйлчилгээг, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд байгууллагын пэйж хуудсаар дамжуулан видео, 13 төрлийн постер, зурагт мэдээллийг хуудас хийн цахим орчинд түгээн ажилласан. Мөн 2100 ширхэг календорыг хэвлүүлэн иргэдэд тархаасан. 13-р сургууль дээр БШУГ-ын удирдлага, мэргэжилтнүүдтэй 2-р ангийн хүүхдийн асуудлаар ажиллаж, албан шаардлага хүргүүлсэн. Эрсдэлт нөхцөлд байгаа гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогч, гэрч, яллагдагч 9 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон ажиллаж, хүүхдийн эрхийг хамгаалж, эцэг эх асран хамгаалагч наарт хууль эрх зүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгч, эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучилж, өмгөөллийн үйлчилгээнд 4 хүүхдийг хамруулж ажилласан.		
3	Хүүхдийн ордоны хөгжлийн хөтөлбөр, хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах	Хүүхэд хөгжлийн хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоог 500 хүргэх	хамрагдсан хүүхдийн тоог 400	500	Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр Хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газраас баталсан "Хүүхдийн оролцоог дэмжих удирдамж"-ийг 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Орхон аймгийн хүүхдийн оролцооны байгууллага нь 3 шатлалт нэгдсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.	2024.01.01 2024.12.30	100

65

					<p>Ерөнхий боловсролын сургуульд хүүхдийн оролцооны 1-р шаталын 125 байгууллагад 1800 хүүхэд гишүүнчлэлээр хамрагдсан. Мөн ерөнхий боловсролын 15 сургуульд Хүүхдийн дэд зөвлөл байгуулж, 1120 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулан тогтмолжсон. 2024 оны хичээлийн жилд, сайн үйлсийн аян, эрүүл мэндийн боловсрол олгох, манлайллын ур чадвар олгох чиглэлээр уулзалт, сургалт гэх мэт нийт 15 төрлийн үйл ажиллагаанд 2000 орчим хүүхдийг хамруулсан.</p> <p>Хүүхдийн ордны хөгжлийн хөтөлбөрт урлаг, уран сайхан, урлах эрдэм, гадаад хэл, оюуны хөгжлийн чиглэлийн 24 хөгжлийн хөтөлбөр хичээллэж байгаа бөгөөд, сард дунджаар 360-520 орчим хүүхэд хамрагдаж, өөрийн авьяас билгээ нээн илрүүлж байна. Мөн оролцооны байгууллагын хүүхдүүдийн дунд сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулж, нийт 300 гаруй хүүхэд хамруулсан. Хүүхдүүд өөрсдөө тэмцээний хөтөлбөр удирдамжaa боловсруулж хамтран зохион байгуулалтад орж багаар ажиллах аргад суралцсан үр дүнтэй байлаа.</p>		
4	Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь хэрэгжүүлсэн байна.	хэрэгжилт 95%	100%	<p>Аймгийн залуучуудын салбар зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, хурлаар 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны төлөвлөгөө хэлэлцэн боловсруулсан. Баян-Өндөр сумын 27 багийн залуучуудын салбар зөвлөлийн төлөөллүүдтэй “Залуучуудаа сонсъё” уулзалт зохион байгуулж, залуучуудын ордны үйл ажиллагааг танилцуулж, тэдний санал хүсэлтийг сонссон. Багийн залуучуудын салбар зөвлөлийн гишүүд 50 гаруй залуу оролцсон. Тус уулзалтаас гарсан саналыг нэгтгэн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Мөн залуучуудад чиглэсэн ямар үйлчилгээ үйл ажиллагаа хэрэгцээтэй байгаа талаар цахим судалгаанд 350 залуучууд хамрагдсан. Тайлант жилд залуучуудын хөгжлийн хөтөлбөрт орон нутгийн төсвөөс 80,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй залуучууд болон өсвөр үе залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, гэр булийн боловсрол олгох, нөхөн үржихүйн сургалт, сэтгэл зүйн нөлөөллийн үйл ажиллагааг зохион</p>	2024.01.01 2024.12.30	70

					байгуулах ажлын хүрээнд нийт 72 арга хэмжээнд 9280 залуучуудыг хамруулсан нь аймгийн хэмжээний нийт залуучуудын 42.2 хувьд хүрч ажилласан байна. Цахим хандалт 15500 /давхардсан тоогоор/ Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарцааны бизнес сайн дүрын ажлыг дэмжих холбон зуучлах ажлын хүрээнд "Бид зорилготой залуус" цуврал зорилтот нэвтрүүлэг, Хойд бүсийн залуучуудын чуулган, залуучуудын тэтгэлэгийг 21 залууд, "Эх оронч залуу" арга хэмжээ, "Ирээдүйн эзэд" мэргэжил сонголтын үндэсний аян, зэрэг арга хэмжээг зохион байгуулсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 84.6%		
5	Жендерийн боловсролыг бүх нийтэд олгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувь хэрэгжүүлсэн байна	хэрэгжилт 60%	70%	2024 онд жендерийн салбар зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, тайлант онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан 25 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлснээр Жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнүүдэд нийт 5590 иргэнийг хамруулсан байна. Үүнд: "Батгэгээн эрдэм" төрийн бус байгууллагатай хамтран "Жендер ба үе тэнгийн харилцаа" сэдэвт сургалт ярилцлагыг үе шаттай зохион байгуулж, 12 сургуулийн 1440 гаруй өсвөр залуучуудыг хамруулсан. Үе тэнгийн дээрэлхэлт, хорт зуршлын талаарх мэдлэг мэдээлэл дээшилсэн. Өсвөр насны охид эмэгтэйчүүдэд "Шүүдэр охидын төв"-өөр дамжуулан нөхөн үржихүйн эрүүл мэнд, гадаад хэл, амьдрах ухаан, хувь хүний хөгжил зэрэг сургалт нөлөөллийн 12 төрлийн арга хэмжээг зохион байгуулж 1500 өсвөр үе охидыг хамруулсанар нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендерт суурилсан хүчирхийллээс өөрийгөө хамгаалах мэдлэг мэдээлэлтэй болсон. Жендерт суурилсан хүчирхийллийн хохирогч иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлдэг "Гэр төсөл"-ийн сэтгэл зүйч Мөнхмаа-д 3.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан "Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгахад 2024-2027 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээ"-ний арга хэмжээний талаар танилцуулах 3 удаагийн онлайн сургалтад жендерийн салбар хороо, Баян-Өндөр, Жаргалант сум, төрийн байгууллагын нийт 150 гаруй албан хаагч хамрагдаж мэдээлэл авсан. Мөн жендерт суурилсан	2024.01.01 2024.12.30	100

хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аяныг "Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй" уриан дор зохион байгуулна. Монгол улсын их сургуулийн Болдхүү багштай хамтран "Жендер ба авлига" тандалт судалгааг цахим болон цаасаар явуулж, нийт 2500 гаруй иргэн хамрагдсан. Дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар одоогийн байдлаар хөтөлбөрийн хэрэгжилт 93 хувьтай байна.

**ГУРАВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ, ЗӨВЛӨМЖ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД**

ГУРАВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ, ЗӨВЛӨМЖ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.	TAX-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Холбогдох албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна	-	Албан бичгийг хугацаанд нь шийдвэр лэн холбогдох газарт хүргүүлсэн байна.	<ul style="list-style-type: none"> ➤ TAX-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, хэлтсийн даргаар батлуулсан. ➤ Төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хагас жилийн байдлаар хариуцсан салбарын чиг үүргийн хүрээнд нийт 72 бичиг ирсэн. Холбогдох нэгж, агентлагтай хамтран ажиллаж хугацаанд нь шуурхай гүйцэтгэсэн. 	2024.01.01 2024.12.30	100
2.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдолыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн	Хууль тогтоожийн хэрэгжилт		Хууль тогтоомжын хэрэгжилтийг ханган ажиллан а	<ul style="list-style-type: none"> ➤ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн дагуу Жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрийн 2021-2023 оны бичиг баримтыг архивд хүлээлгэн өгсэн. ➤ Тайлант жилийн хугацаанд хагас жилийн байдлаар нийт 7 өргөдөл ирсэн. Холбогдох байгууллагад нь мэдээлэл хүргэн хамтран ажиллаж хугацаанд нь шуурхай гүйцэтгэсэн. <p>Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн, авлига ашиг сонирхлоос ангид ажилласан.</p>	2024.01.01 2024.12.30	100

45

	гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
	Өргөдөл хүсэлтийг хугацаанд шийдвэрлэх	гомдол, хуулийн шуурхай	Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо 20	Өргөдөл гомдлын тоо 15	Өргөдөл гомдлыг шийдвэр лэсэн байх	> Тайлант жилийн байдлаар нийт 7 өргөдөл, хүсэлтийг холбогдох нэгж газартай хамтран мэдээлэл хүргэн, хамтран ажиллаж хугацаанд нь шуурхай шийдвэрлэсэн.	2024.01.01 2024.12.30	100
	Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх	Комисс, ажлын хэсэгт ажилласан тоо 7	тоо 5	Шийдвэр ийн дагуу ажиллах	Засаг даргын захирамжаар байгуулагдсан 3 ажлын хэсэгт орж ажилласан. Үүнд <ul style="list-style-type: none"> > 2024 оны 01 дүгээр сарын 18 нийт өдрийн A/38 тоот захирамжаар байгуулагдсан жендерийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг, > 2024 оны 05 дугаар сарын 03ний өдрийн A/326 тоот захирамжаар байгуулагдсан Гэр бүлийн өдрийг зохион байгуулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар, > 2024 оны 05 дугаар сарын 10 нийт өдрийн A/349 тоот захирамжаар Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр Хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэгт тус тус шийдвэрийн дагуу ажилласан. > Улсын баяр наадмыг зохион байгуулах ажлын хэсэг тус тус ажилласан. Мөн байгууллагын шуурхай хуралдаанаас нийт -31 үүрэг даалгавар ирснийг холбогдох байгуулагуудад хүргэж, хэрэгжилтийг удирдлагуудад танилцуулж шуурхай гүйцэтгэж ажилласан.	2024.01.01 2024.12.30	100	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин					
		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин биелэлт	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Байгууллагын зүгээс зохион байгууласан сургалт үйл ажиллагаанд хамрагдах.	2	3	4	5	6	7
	Өөрийгөө хөгжүүлэх сургалтад	Ажил үүргийн холбогдолтой сургалт үйл ажиллагаанд	1	Байгууллагын зүгээс зохион байгуулсан нийт 6 сургалтад хамрагдсан. Үүнд <ul style="list-style-type: none"> > Байгууллагын соёл 	2024.01.01 2024.12.05	100	

		хамрагдсан байна.			<ul style="list-style-type: none"> ➤ Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт ба төсөвлөлт ➤ Цахим эрдэнэт ➤ ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан сургалт ➤ Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан сургалт ➤ Хойд бүсийн чуулган зэрэг байгууллагаас зохион байгуулсан сургалт үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдсан. ➤ Удирдлын академийн Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл" сэдэвт цахим, танхим хосолсон богино хугацааны сургалтад хамрагдаж үнэмлэх авсан. ➤ Жендерийн мэргэжилтэн, шинжээчдийг чадавхжуулах сургалтад хамрагдсан. ➤ Мөн төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдаж буй сургалтуудад тухай бурд нь оролцож байна. 		
2.	Япон улсын хүүхэд хүмүүслийн зэрэг арга "ТОККАЦУ" сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байна.	-	1	Япон боловсролын онцлог "Токкацу" төсөл Орхон аймагт 2 дахь жилдээ амжилттай хэрэгжиж байна. Төслийн хүрээн хүүхэд хүмүүжлийн зэрэг арга зүй модуль сургалтын орчуулага, зохион байгуулалтыг хариуцан ажиллаж, "Токкацу"-ыг түгээн дэлгэрүүлэх сургагч багшийн сертифкат авсан. Мөн Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын эцэг эхийг зөвлөлтэй хамтран ажилтан албан хаагч наарт сургалтыг зохион байгуулж нийт 50 орчин ажилтан хамрагдсан.	2024.01.01 2024.12.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН :

Н.БААСАНСҮРЭН/ Н.Баасан /

2024.12.05

(Нэр, гарын үсэг)

(Огноо)

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД,
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)